

**Аудитын код: САГ-2018/401/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)


Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663, Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер С.Оюунгэрэл  
Утас: 261885, Цахим хаяг: [oyungerels@audit.gov.mn](mailto:oyungerels@audit.gov.mn)

Аудитор Д.Цэгмиддорж  
Утас: 261740, Цахим хаяг: [tsegmiddorjd@audit.gov.mn](mailto:tsegmiddorjd@audit.gov.mn)

“Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал, Аудитор П.Шаравхорол  
Утас: 7011-4519, Цахим хаяг: [sharav\\_8054@yahoo.com](mailto:sharav_8054@yahoo.com)

Ахлах аудитор Д.Лхамсүрэн  
“Лидер экаунт аудит” ХХК  
Утас: 7011-4519, Цахим хаяг: [lhama\\_0324@yahoo.com](mailto:lhama_0324@yahoo.com)



## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ.....	1
2	Аудитын тайлан .....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	2
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	3
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	3
2.5	Дотоод хяналт.....	4
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл .....	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	5
2.9.1	Авлагын талаар .....	5
2.9.2	Тооллого тооцооны талаар .....	5
2.9.3	Түрээсийн төлбөрийн талаар.....	5
2.9.4	Нэг удаагийн тэтгэмжийн талаар.....	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар: .....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	7
3	Менежментийн захидал .....	9
3.1	Авлагын талаар .....	11
3.2	Тооллого тооцооны талаар .....	12
3.3	Нэг удаагийн тэтгэмжийн талаар.....	14
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	16
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	16
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	18
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	20
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	23
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	24



**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/474  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ШИНЭ ЭРИН” ОЛОН УЛСЫН  
ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ  
ТӨРИЙН ӨМЧИТ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.АМАРТҮВШИН ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтөлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



070576

**01**

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 1 Аудитын тайлан

### 1.1 Оршил

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус сургуулийн захирал Б.Амартүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын тооцоог нэгтгэж баримтжуулах, он дамжсан авлагыг барагдуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 26-наас 2018 оны 2 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн “Лидер экаунт аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Лхамсүрэн, аудитор Э.Учралзаяа, аудиторын туслах Ш.Уянга нар хэрэгжүүлж ажиллав.

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 15-ний өдрийн 02/02 дугаартай албан бичгээр “Лидер экаунт аудит” ХХК-д ирүүлсэн.

### 1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

Тус сургууль нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас олгосон тусгай зөвшөөрөлд заасан шаардлага, хяналтын үзүүлэлтүүдийн дагуу улсын хэмжээнд Кембрижийн олон улсын хөтөлбөрөөр хичээллэх сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

### 1.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 9,029.3 мянган төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “ACOLOUS” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

## 1.5 Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтын ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч дотоод хяналтын чиглэлээр мэргэжлийн ажилтан байхгүй байна.

## 1.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төв төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тус байгууллагын төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 878,464.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 875,333.3 мянган төгрөг зарцуулж, төсвийн үлдэгдэл 3,131.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн данс оны эхний үлдэгдэлгүй байна.

## 1.7 Шилэн дансны мэдээлэл

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль 2017 онд Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах мэдээллүүдийг хуулийн хугацаанд нь байршуулж ажилласан байна.

Тайлант онд тус сургуулийн хувьд цахим санд 10 төрлийн мэдээллийг жил, улирал, сарын давтамжтай мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## 1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

## 1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

### 1.9.1 Авлагын талаар

БСШУСЯ-ын харъяа “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль нь төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох 154 м2 талбай бүхий өрөөг цайны газрын зориулалтаар “Халиунбат арвижих” ХХК-д түрээслүүлсэн боловч 531.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.



### 1.9.2 Тооллого тооцооны талаар

Оны эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын тооцоог нэгтгэж баримтжуулаагүй, тайлан илтгэх хуудас байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

### 1.9.3 Түрээсийн төлбөрийн талаар

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль нь өөрийн эзэмшлийн 154 м2 талбай бүхий өрөөг цайны газрын зориулалтаар “Халиунбат Арвижих” ХХК-д түрээслүүлж, түрээсийн төлбөрт 2017 онд 2,502.5 мянган төгрөгийг төлүүлэн авсан байна. Түрээсийн төлбөрийн 30 хувь болох 750.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна”, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 17-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 102 дугаар тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Гэхдээ үйл ажиллагааны орлого болох түрээсийн төлбөрт төвлөрүүлсэн 2,502.5 мянган төгрөгийг “Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлогыг зарцуулах тухай” Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 372 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу 2,502.5 мянган төгрөгийг буцаан авч зарцуулжээ.

Шийдвэрлэсэн: Түрээсийн төлбөрийн 30 хувь болох 750.7 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоох


### 1.9.4 Нэг удаагийн тэтгэмжийн талаар

Тус сургуульд нягтлан бодогчоор ажиллаж байсан Л.Лхам-Эрдэнэд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн нийт 20,043.9 мянган төгрөгнөөс үлдэгдэл 9,443.9 мянган төгрөгийг олгохдоо тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланг залруулах

### 1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.



### 1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад дараагийн аудитаар авч үзэх материаллаг асуудал гараагүй.

### 1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Түрээсийн төлбөрийн 30 хувь болох 750.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна”, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 17-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 102 дугаар тогтоолын 2-т “Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хэмжээг түрээсийн нийт орлогын 30 хувиар тогтоож, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1 хувиар тооцож 9,029.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

### 1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

Хоёр дахь шатанд хянасан:

“Лидер экаунт аудит” ХХК-ийн захирал

/П.Шаравхорол/

Анхан шатанд хянасан:

Чанарын хяналтын менежер

/И.Юмчиндулам/

Бэлтгэсэн: Аудитор

/Д.Лхамсүрэн/



## 2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



**Асуудал 1: Авлагын талаар**

**ТЭРГҮҮЛЭХ АЧ ОЛБОГДОЛ №1**

**Ажиглалт :**

БСШУСЯ-ын харъяа “Шинэ эрин” олон улсын хөтөлбөрийн сургалттай төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль нь төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох 154 м2 талбай бүхий өрөөг цайны газрын зориулалтаар “Халиунбат арвижих” ХХК-д түрээслүүлсэнээс түрээсийн төлбөр 531.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчжээ.

**Зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Энэхүү зөвлөмжийг 2018 оны 04 дугаар сарын 30-ны дотор хэрэгжүүлнэ гэсэн хариу ирүүлсэн.

**Эрсдэлүүд:**

- Найдваргүй авлага нэмэгдэж хөрөнгө зүй бусаар зарцуулагдах
- Хууль зөрчигдөх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ.



**Асуудал 2: Хөрөнгийн тооллогын талаар**

**ТЭРГҮҮЛЭХ АЧ ОЛБОГДОЛ №1**

**Ажиглалт :**

Оны эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын тооцоог нэгтгэж баримтжуулаагүй, тайлан илтгэх хуудас байхгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” гэснийг мөрдөөгүй байна.

**Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

Энэхүү зөвлөмжийг 2018 оны 03 дугаар сарын 30-ны дотор хэрэгжүүлнэ гэсэн хариу ирүүлсэн.

**Эрсдэлүүд:**

Өмч хөрөнгө дутагдах, шамшигдах эрсдэлтэй.

**Төсвийн захирагчийн хариу**

Өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.



**Асуудал 3: нэг удаагийн тэтгэмжийн**

**ТЭРГҮҮЛЭХ АЧ ОЛБОГДОЛ №1**

**ТАЛААР**

**Ажиглалт :**

Тус сургуульд нягтлан бодогчоор ажиллаж байсан Л.Лхам-Эрдэнэд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн үлдэгдэл 9,443.9 мянган төгрөгийг олгохдоо тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

**Зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах

Энэхүү зөвлөмжийг 2018 оны 04 дугаар сарын 30-ны дотор хэрэгжүүлнэ гэсэн хариу ирүүлсэн.

**Эрсдэлүүд:**

Энэ нь санхүүгийн тайлан үнэн зөв байх, толилуулга, тодруулга, батламж мэдэгдлийг хангахгүй байх эрсдэлтэй

- Хууль зөрчигдөх

**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ.







**Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>95,802,629.13</b>	<b>104,288,458.63</b>
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	-	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Төгрөг	-	-
<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>Төгрөг</b>	-	-
Төрийн сангийн харилцах	-	-
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
<b>АВЛАГА</b>	<b>852,621.09</b>	<b>831,751.33</b>
Ажиллагсадтай холбогдсон авлага	300,000.00	300,000.00
Бусад авлага	552,621.09	531,751.33
Байгууллагаас авах авлага	552,621.09	531,751.33
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>94,950,008.04</b>	<b>103,456,707.30</b>
Түүхий эд материал	50,981,037.14	56,113,373.50
Тусгай зориулалттай материал	50,981,037.14	56,113,373.50
Хангамжийн материал	43,968,970.90	47,343,333.80
Бичиг хэргийн материал	1,599,507.00	1,834,142.00
Аж ахуйн материал	35,385,241.00	36,437,845.00
Сэлбэг хэрэгсэл	345,000.00	414,000.00
Түлш шатах тослох материал	41,135.00	537,173.80
Бусад хангамжийн материал	6,598,087.90	8,120,173.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,454,414,462.59</b>	<b>2,318,977,882.25</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,454,414,462.59</b>	<b>2,318,977,882.25</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>2,438,279,411.91</b>	<b>2,314,494,260.38</b>
Барилга, байгууламж	2,049,844,964.00	2,049,844,964.00
Хуримтлагдсан элэгдэл	(115,356,313.13)	(149,520,395.81)
Авто тээврийн хэрэгсэл	60,800,000.00	60,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(39,519,999.90)	(60,800,000.00)
Машин, тоног төхөөрөмж	407,755,611.87	407,755,611.87
Хуримтлагдсан элэгдэл	(245,278,633.58)	(254,862,672.98)
Тавилга, аж ахуйн эд хогшил	469,421,581.06	469,421,581.06
Хуримтлагдсан элэгдэл	(236,345,439.44)	(294,777,068.83)
Бусад үндсэн хөрөнгө	8,800,000.00	8,800,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,759,999.92)	(2,639,999.88)
Номын фонд	79,917,640.95	80,472,240.95
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>16,135,050.68</b>	<b>4,483,621.87</b>
Програм хангамж	48,767,381.74	48,767,381.74
Хасагдуулга	(32,632,331.06)	(44,283,759.87)

**“ШИНЭ ЭРИН” ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,550,217,091.72</b>	<b>2,423,266,340.88</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>4,491,331.00</b>	<b>-</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,491,331.00</b>	<b>-</b>
<b>Өглөг</b>	<b>4,491,331.00</b>	<b>-</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	12,000.00	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,479,331.00	-
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,545,725,760.72</b>	<b>2,423,266,340.88</b>
Засгийн газрын хувь оролцоо	2,545,725,760.72	2,423,266,340.88
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн	3,132,187,517.32	3,132,187,517.32
Өмч: - төрийн	3,132,187,517.32	3,132,187,517.32
Хуримтлагдсан үр дүн	(586,461,756.60)	(708,921,176.44)
Өмнөх үеийн үр дүн	(586,461,756.60)	(586,461,756.60)
Тайлант үеийн үр дүн		(122,459,419.84)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,550,217,091.72</b>	<b>2,423,266,340.88</b>



**Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>888,676,022.16</b>	<b>902,930,067.27</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>80,642,668.98</b>	<b>2,503,267.27</b>
Нийтлэг татварын бус орлого	80,642,668.98	2,503,267.27
Төсөвт байгууллагын өөрийн орлого	80,642,668.98	2,503,267.27
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,009,131.47	2,503,267.27
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,633,537.51	
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>808,033,353.18</b>	<b>900,426,800.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	800,861,500.00	881,574,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	800,861,500.00	881,574,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	7,171,853.18	18,852,000.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан		1,627,000.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ашиглагдаагүй	720,000.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	6,000,000.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны		17,225,000.00
Төсвийн урамшуулал	451,853.18	
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>916,878,167.87</b>	<b>1,025,389,487.11</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>909,625,000.67</b>	<b>997,213,956.24</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>909,625,000.67</b>	<b>997,213,956.24</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>619,874,683.35</b>	<b>671,927,943.13</b>
Цалин	619,874,683.35	671,927,943.13
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>68,759,948.00</b>	<b>76,108,228.19</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	44,445,208.00	49,728,429.61
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,301,960.00	3,756,310.51
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	6,191,876.00	6,630,242.90
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,963,258.00	3,096,308.03
Эрүүл мэндийн даатгалын хураамж	11,857,646.00	12,896,937.14
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,452,892.25	37,617,800.13
Гэрэл цахилгааны зардал	16,711,504.00	18,370,672.00
Түлш, халаалтын зардал	23,351,731.40	18,864,780.91
Цэвэр, бохир усны зардал	3,389,656.85	382,347.22
Хангамж, бараа материалын зардал	22,913,699.67	22,711,904.81
Бичиг хэргийн материал	3,583,063.00	5,503,185.00
Тээвэр, шатахууны зардал	4,449,300.00	4,194,344.20
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,433,630.48	10,106,102.21

**“ШИНЭ ЭРИН” ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Ном, хэвлэлийн зардал	139,400.00	307,600.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,308,306.19	2,600,673.40
Нормативт зардал	188,628.00	346,268.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	188,628.00	346,268.00
Эд хогшил, урсгал засварын зардал	3,499,350.00	8,484,122.00
Урсгал засвар	3,499,350.00	8,484,122.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,033,978.00	18,885,805.80
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	4,668,452.00	16,257,585.80
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	131,900.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,800.00	33,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээний хөлс	3,178,826.00	463,320.00
Бараа үйлчилгээний бусад зардал	140,901,821.40	161,131,884.18
Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал	14,834,577.27	25,140,703.84
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,067,244.13	135,991,180.34
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,253,167.20</b>	<b>28,175,530.87</b>
Бусад урсгал шилжүүлэг		25,043,900.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		9,443,900.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		15,600,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,253,167.20	3,131,630.87
Төвлөрүүлэх шилжүүлэг	7,253,167.20	3,131,630.87
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(28,202,145.71)</b>	<b>(122,459,419.84)</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>(28,202,145.71)</b>	<b>(122,459,419.84)</b>




**Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>832,419,136.65</b>	<b>932,636,504.27</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,009,131.47</b>	<b>19,161,857.27</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,009,131.67</b>	<b>19,161,857.27</b>
<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,009,131.47</b>	<b>19,161,857.27</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,009,131.47	19,161,857.27
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>828,410,005.18</b>	<b>913,474,647.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>800,861,500.00</b>	<b>881,574,800.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	800,861,500.00	881,574,800.00
<b>Нэмэлт санхүүжилтын орлого</b>	<b>7,171,853.18</b>	<b>21,354,500.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй	720,00.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	6,000,000.00	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилла		19,727,500.00
Төсвийн урамшуулал	451,853.18	
<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,376,652.00</b>	<b>10,545,347.00</b>
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	20,376,652.00	10,545,347.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>831,649,138.65</b>	<b>932,081,904.27</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>831,649,138.65</b>	<b>932,081,904.27</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>824,395,971.45</b>	<b>903,906,373.40</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>631,034,185.91</b>	<b>682,473,290.13</b>
Үндсэн цалин	631,034,185.91	680,138,290.13
Үр дүнгийн урамшуулал		2,335,000.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>68,910,843.45</b>	<b>76,134,628.43</b>
Тэтгэврийн даатгалын шимтгэл	68,910,843.45	76,134,628.43
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,452,892.25</b>	<b>37,617,800.13</b>
Гэрэл, цахилгааны зардал	16,711,504.00	18,370,672.00
Түлш, халаалтын зардал	23,351,731.40	18,864,780.91
Цэвэр, бохир усны зардал	3,389,656.85	382,347.22
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,806,354.67</b>	<b>28,331,337.21</b>
Бичиг хэрэг	4,208,400.00	5,821,590.00
Тээвэр, шатахуун	4,481,000.00	4,656,100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,954,299.48	14,585,433.21
Ном, хэвлэл	227,400.00	367,600.00

**“ШИНЭ ЭРИН” ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	935,255.19	2,900,614.00
<b>Нормативт зардал</b>	<b>808,500.00</b>	<b>791,554.00</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	808,500.00	791,554.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,214,600.00</b>	<b>8,323,200.00</b>
Урсгал засвар	6,214,600.00	8,323,200.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,286,708.00</b>	<b>24,866,285.80</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	5,609,382.00	16,365,185.80
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	131,900.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,800.00	33,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,490,626.00	6,336,200.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,881,887.17</b>	<b>45,368,277.70</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	20,376,652.00	19,140,090.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,505,235.17	26,228,187.70
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,253,167.20</b>	<b>28,175,530.87</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>25,043,900.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		9,443,900.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		15,600,000.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,253,167.20</b>	<b>3,131,630.87</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	7,253,167.20	3,131,630.87
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>769,998.00</b>	<b>554,600.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН</b>		
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,258,000.00</b>	<b>554,600.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,258,000.00</b>	<b>554,600.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,258,000.00</b>	<b>554,600.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,258,000.00	554,600.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(2,258,000.00)</b>	<b>(554,600.00)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,488,002.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00






Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>0.00</b>	<b>(558,259,610.89)</b>	<b>2,573,927,906.43</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>0.00</b>	<b>(558,259,610.89)</b>	<b>2,573,927,906.43</b>
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	(28,202,145.71)	(28,202,145.71)
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>0.00</b>	<b>(586,461,756.60)</b>	<b>2,545,725,760.72</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,132,187,517.32	0.00	(586,461,756.60)	2,545,725,760.72
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.00	0.00	(122,459,419.84)	(122,459,419.84)
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>0.00</b>	<b>(708,921,176.44)</b>	<b>2,423,266,340.88</b>






**Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>881,574,800.00</b>	<b>878,464,936.40</b>	<b>3,109,863.60</b>	<b>99.6%</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>881,574,800.00</b>	<b>878,464,936.40</b>	<b>3,109,863.60</b>	<b>99.6%</b>
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>856,230,900.00</b>	<b>853,421,036.40</b>	<b>2,809,863.60</b>	<b>99.7%</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>669,923,900.00</b>	<b>669,592,943.13</b>	<b>330,956.87</b>	<b>100.0%</b>
Үндсэн цалин	395,623,000.00	395,292,043.13	330,956.87	96.62%
Нэмэгдэл	206,656,800.00	206,656,800.00	-	100.0%
Унаа, болон бусад нөхөн олговор	38,093,200.00	38,093,200.00	-	100.0%
Урамшуулал	29,550,900.00	29,550,900.00	-	100.0%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,910,800.00</b>	<b>75,877,778.43</b>	<b>33,021.57</b>	<b>99.96%</b>
Тэтгэврийн даатгал	49,113,800.00	49,080,778.43	33,021.57	99.96%
Тэтгэмжийн даатгал	6,699,200.00	6,699,200.00	-	100.0%
ҮОМШӨ-ний даатгал	5,359,400.00	5,359,400.00	-	100.0%
Ажилгүйдлийн даатгал	1,339,900.00	1,339,900.00	-	100.0%
Эрүүл мэндийн даатгал	13,398,500.00	13,398,500.00	-	100.0%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,617,900.00</b>	<b>37,617,800.13</b>	<b>99.87</b>	<b>100.0%</b>
Гэрэл, цахилгаан	19,013,800.00	18,370,672.00	643,128.00	96.6%
Түлш, халаалт	16,749,700.00	18,864,780.91	(2,115,080.91)	112.6%
Цэвэр, бохир ус	1,854,400.00	382,347.22	1,472,052.78	20.6%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,939,900.00</b>	<b>26,936,562.21</b>	<b>3,337.79</b>	<b>100.0%</b>
Бичиг хэрэг	4,392,800.00	4,545,540.00	(152,740.00)	103.5%
Тээвэр, шатахуун	4,679,600.00	4,656,100.00	23,500.00	99.5%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,349,900.00	14,550,433.21	799,466.79	94.8%
Ном, хэвлэл	631,900.00	642,200.00	(10,300.00)	101.6%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,885,700.00	2,542,289.00	(656,589.00)	134.8%
<b>Нормативт зардал</b>	<b>816,000.00</b>	<b>791,554.00</b>	<b>24,446.00</b>	<b>97.0%</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	816,000.00	791,554.00	24,446.00	97.0%
<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>8,323,200.00</b>	<b>8,323,200.00</b>		<b>100.0%</b>
Урсгал засвар	8,323,200.00	8,323,200.00		100.0%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>134,000.00</b>		<b>134,000.00</b>	
Дотоод албан томилолт	134,000.00		134,000.00	
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>11,630,600.00</b>	<b>9,400,010.80</b>	<b>2,230,589.20</b>	<b>80.8%</b>

**“ШИНЭ ЭРИН” ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,610,200.00	3,401,410.80	2,208,789.20	60.6%
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,000,000.00	2,000,000.00		100.0%
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	131,900.00		100.0%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,800.00	33,000.00	21,800.00	60.2%
Мэдээллийн технологийн зардал	3,833,700.00	3,833,700.00		100.0%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,934,600.00</b>	<b>24,881,187.70</b>	<b>53,412.30</b>	<b>99.8%</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,934,600.00	24,881,187.70	53,412.30	99.8%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,343,900.00</b>	<b>25,043,900.00</b>	<b>300,000.00</b>	<b>98.8%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,343,900.00</b>	<b>25,043,900.00</b>	<b>300,000.00</b>	<b>98.8%</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,443,900.00	9,443,900.00		100.0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,900,000.00	15,600,000.00	300,000.00	98.1%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>881,574,800.00</b>	<b>878,464,936.40</b>	<b>3,109,863.60</b>	<b>99.6%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>881,574,800.00</b>	<b>878,443,169.13</b>	<b>3,131,630.87</b>	<b>99.6%</b>
Улсын төсвөөс санхүүжих	881,574,800.00	878,443,169.13	3,131,630.87	99.6%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		<b>21,767.27</b>	<b>(21,767.27)</b>	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		21,767.27	(21,767.27)	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>		<b>100.0%</b>
Төсвийн байгууллага	1.00	1.00		100.0%
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>56.00</b>	<b>56.00</b>		<b>100.0%</b>
Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%
Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00		100.0%
Үйлчлэх ажилтан	12.00	12.00		100.0%
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/</b>				
<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>				
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>				
Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/				
Төрийн тусгай албан хаагч /ТТ/				
Ажлын албаны албан хаагч /АА/				
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/				
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хагч /ТҮШУ/				
Соёл урлагын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮСУ/				




Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮМБ/				
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/				
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/				
Гэрээт ажилтан				
Улс төрийн албан хаагч /УТ/				



**Аудит хийгдсэн нэмэлт төсвийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		0.00	0.00	
<b>I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		21,354,500.00	(21,354,500.00)	
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		21,354,500.00	(21,354,500.00)	
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		21,354,500.00	(21,354,500.00)	
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		2,335,000.00	(2,335,000.00)	
Урамшуулал		2,335,000.00	(2,335,000.00)	
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		256,850.00	(256,850.00)	
Тэтгэврийн даатгал		256,850.00	(256,850.00)	
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1,669,375.00	(1,669,375.00)	
Бичиг хэрэг		1,276,050.00	(1,276,050.00)	
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		35,000.00	(35,000.00)	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		358,325.00	(358,325.00)	
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>		15,466,275.00	(15,466,275.00)	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		12,963,775.00	(12,963,775.00)	
Мэдээллийн технологийн зардал		2,502,500.00	(2,502,500.00)	
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		1,627,000.00	(1,627,000.00)	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,627,000.00	(1,627,000.00)	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		21,354,500.00	(21,354,500.00)	
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		2,505,500.00	(2,502,500.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,505,500.00	(2,502,500.00)	
<b>Нэмэлт санхүүжилтын орлого</b>		18,852,000.00	(18,852,000.00)	
Төсвийн байгууллагын үндэн үйл ажиллагааны хүрээн бий болсон нэмэлт		18,852,000.00	(18,852,000.00)	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		0.00	0.00	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		0.00	0.00	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00		100.0%
Төсвийн байгууллага	1.00	1.00		100.0%
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	56.00	56.00		100.0%
Удирдах ажилтан	1.00	1.00		100.0%



**“ШИНЭ ЭРИН” ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРИЙН СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Гүйцэтгэх ажилтан	43.00	43.00		100.0%
Үйлчлэх ажилтан	12.00	12.00		100.0%
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/</b>				
<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>				
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>				
Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/				
Төрийн тусгай албан хаагч /ТТ/				
Ажлын албаны албан хаагч /АА/				
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/				
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хагч /ТҮШУ/				
Соёл урлагын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮСУ/				
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮМБ/				
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/				
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/				
Гэрээт ажилтан				
Улс төрийн албан хаагч /УТ/				

